



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 428

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 36 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон нийт 419,000,000.00 (дөрвөн зуун арван есөн сая) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Гадаадын иргэн, харьяатын газар, түүний харьяа газруудад эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001362

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 4 дугаар сарын 29-ны өдрийн
428 дугаар тогтоолын хавсралт



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУДАЛТААР
БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ,
ГАДААДЫН ИРГЭН ХАРЬЯАТЫН ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА АЙМАГ ГАЗРУУДАД
ДАХЬ ГАЗРУУДАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк, арлын дугаар	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)
1.Гадаадын иргэн, харьяатын газар				
1	Хьюндай элентра 77-66 УБУ (арал-kmhd741cblu967303)	1	62,500,000.00	62,500,000.00
2	Хьюндай соната DN8, 04-63 УБУ (арал-kmhl3416bla039744)	1	85,000,000.00	85,000,000.00
	Дүн			147,500,000.00
2.ГИХГ-ын Баруун бүс дэх газар				
1	УАЗ 220695-04 фургон, 76-46 УБО (арал-xtt220695li201335)	1	40,750,000.00	40,750,000.00
	Дүн			40,750,000.00
3.ГИХГ-ын Зүүн бүс дэх газар				
1	УАЗ 220695-04 фургон, 74-39 ДОА (арал-xtt220695li200744)	1	40,750,000.00	40,750,000.00
	Дүн			40,750,000.00
4.ГИХГ-ын Хойд бүс дэх газар				
1	Тоёота ландкрузер 200, 10-23 ДГА (арал-jtmhvoij504281345)	1	190,000,000.00	190,000,000.00
	Дүн			190,000,000.00
	Нийт дүн			419,000,000.00